

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.02.26-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрээс:

3.1. “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар”-ын төслийг хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

3.2. Монгол Улсын Шадар сайдтай аймгуудын Засаг дарга нарын байгуулсан гэрээний биелэлтэд /ОББ-д хамаарах заалтад/ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнтэй танилцав.

3.3. Архангай аймгийн Онцгой байдлын газарт албаны шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ОБЕГ-ын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрлэхээр тогтов.

3.4. Баянхонгор аймгийн Онцгой байдлын газарт албаны шалгалт явуулсан дүнг хэлэлцээд ажлын хариуцлага алдсан тус газрын ахлах нягтлан бодогч, салааны захирагч нарт сахилгын арга хэмжээ тооцохоор шийдвэрлэв.